# ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

В.Пүрэвбаасан
Хилийн стратегийн профессорын багийн
дэд профессор, доктор, хурандаа

С.Түмэн-Өлзий
ДХИС-ийн Удирдлагын академийн
магистрант, хошууч

***Товч агуулга:*** Энэхүү өгүүллээрээ хилийн аюулгүй байдлын талаар судалж, хууль эрх зүйн талаас нь тайлбарлахыг хичээлээ.“Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна”[26] гэж Үндсэн хуульд зааснаар, хөрш улсуудтайгаа сайн хөршийн нөхөрсөг харилцаа тогтоож, дэлхийн улс бүхэнтэй олон улсын эрх тэгш, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан нээлттэй харилцах гадаад бодлого баримталж байна.

***Түлхүүр үгс:*** Монгол улс, төр, бодлого, хил, хилийн аюулгүй байдал, хилийн зурвас, бүс.

## Оршил

Монгол Улсын оршин тогтносон 2200 гаруй жилийн хугацаанд нутаг дэвсгэр хил, хязгаарын төлөө явуулсан тэмцлийн түүхээс харахад түүнд тал бүрээс учирч байсан аюул занал нь манай улс, нутаг дэвсгэр, хүн амыг хүн төрөлхтөний түүхийн тавцангаас зайлуулах, нутаг дэвсгэрийг нь эзэмших, эс чадваас хил орчмын тодорхой газар нутгийг таслаж авах зорилго, чиглэлтэй явагдаж иржээ[27].

Энэхүү өнгөрсөн үеийн түүхэн сургамж нь хүн ам цөөн, газар нутаг өргөнуудам, нийгэм эдийн засгийн хөгжлөөр харьцангуй сул манай улсын хувьд өөрийн аюулгүй байдлыг хангахад нэн түрүүнд улсын хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх явдал юм гэдгийг харуулж байна.

Японы милитаристуудын зүгээс Халхын голын чиглэлээр 70 гаруй жилийн өмнө өдөөсөн дайны зорилго нь Монголын талаас эзэмшилгүй байсан хил орчмын газар нутгийг цэргийн хүчээр, дээрмийн аргаар эзэмшихийн төлөө явагдсаныг бид мартах ёсгүй.

Хилийн аюулгүй байдлын талаар судлахын өмнө аюулгүй байдлын тухай судлах нь зүйтэй юм. “Аюулгүй байдал" гэдэг ерөнхий ойлголтыг Я.Цэвэлийн тайлбар тольд: “аймаар юмгүй, айх болгоомжлох шаардлагагүй”, "аюулгүй байдал

[26]“Монгол Улсын Үндсэн хуулийн 4.1 дэх хэсэг

[27]Жекей Х. “Оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд улсын хил хязгаар, нутгийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь”.УБ.,2004. 38 дахь тал.

гэдэг бол аюулгүй, бүрэн бүтэн байх, найдвартай, итгэлтэй байх" [28] гэж тайлбарлажээ.

Олон улсын хэмжээнд хилийн аюулгүй байдлыг хилийн орон зай (хил, хилийн зурвас, бүс, хил орчмын нутаг дэвсгэр)-д төр, нийгэм, иргэдийн язгуур ашиг сонирхол баталгаатай хамгаалагдсан байх нөхцөлийг хэлдэг бөгөөд хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болдог байна[29]. гэж тэмдэглэсэн байна.

Монгол Улсын оршин тогтнохуйн бүхий л хугацаанд хил хязгаар гэсэн ухагдахуун төрийн бодлогын байнгын анхааралд байж, түүний хамгаалалт нь ямагт улс төр, дипломатын, цэргийн дэглэмийн арга хэмжээгээр голлон хэрэгжиж ирсэн болно. 1962 оноос хойд хилд, 1979 оноос хилийн шугамын хамгаалалт дагнасан байдалтай байгаад 2002 онд Монгол Улсын Их Хурлын тогтоолоор Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого[30]батлагдан гарч хил хязгаарын аюулгүй байдлын хамгаалалтын шинэ үе эхэлсэн гэж хэлж болох юм.

Хилийн аюулгүй байдлыг хангах гол асуудал нь хилийн орчинд Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг гадаад, дотоодын аюул, заналаас хамгаалах төр, нийгэм, иргэний аюулгүй байдлыг хангахдаа юуны урьд хилийн талаар байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахих, зэргэлдээ улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх бүх талын бололцоо олгоход гол зүйл юм.Хилийн аюулгүй байдал гэдэг нь “улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр, (хилийн орон зай)-д үндэсний аюулгүй байдал найдвартай хангагдах гадаад, дотоод нөхцөл баталгаатай хангагдах явдал” гэж манай эрдэмтэд үздэг билээ.

Аливаа улсын хил нь нийгэм, улс төрийн ээдрээтэй бодит үзэгдэл мөн бөгөөд түүнийг зэргэлдээ орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллагатай хамтран шийдвэрлэж, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримтаар баталгаажуулан хэрэгжүүлдэг онцлогтой[31].

“Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна”[32] гэж Үндсэн хуульд зааснаар, зэргэлдээх улсуудтайгаа сайн хөршийн нөхөрсөг харилцаа тогтоож, дэлхийн улс бүхэнтэй олон улсын эрх тэгш, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан нээлттэй харилцах гадаад бодлого баримталж байна.

Хил хамгаалах байгууллагад Зэвсэгт хүчний зүгээс дэмжлэг үзүүлэх, хилийн цэргийн анги салбарын ар талд хил халхлах зориулалтын анги салбарыг тайван цагт бүрдүүлж, улсын хилээр цөмөрсөн цэргийн халдлагыг хориглон няцаах, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хэвийн байдалд нь оруулах зэрэг оператив-стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд цэргийн аюулгүй байдал,

[28]Цэвэл Я. “Монгол хэлний товч тайлбар толь”. УБ., 1966 60 дахь тал

[29]3Жекей Х. “Оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд улсын хил хязгаар, нутгийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь”.УБ.,2004. 38. дахь тал.
4Монгол улсын хилийн тухай хууль. “ Төрийн мэдээлэл сэтгүүл №06/963". УБ., 2017.

[30]Арвай Ш. "Монгол улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог”. УБ., 2015. 9 дахь тал.

[31].Арвай Ш. “Улсын хилийн тухай дурсамж, үзэл бодол”. УБ. 2005. 35 дах тал.

[32].Монгол Улсын үндсэн хууль. Цахим эх сурвалж, холбоос. Legalinto.mn

хилийн аюулгүй байдал нь нэгэн зэрэг зорилго, эрх ашгаар холбогддог онцлогтой байна.

Олон улсын хэмжээнд хилийн аюулгүй байдлыг улсын хилийн зурвас, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт төр, нийгэм, иргэдийн язгуур ашиг сонирхол баталгаатай хамгаалагдсан байхыг хэлдэг бөгөөд хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болдог. Хилийн аюулгүй байдал нь хил залгаа улс, улс орны хэмжээнд яригдах өргөн утга агуулгатай улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хил хязгаар нутагт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангахад чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаа юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал нь Монгол Улсын тусгаар тогтнол, улс орны дотоодын бүрэн бүтэн байдал, хорлон сүйтгэх хүчин зүйлүүдэд өртөхгүй байх, гадаад, дотоодын аюул заналыг тэсвэрлэх, оршин тогтнох, хөгжих, өөрт нь учрах аливаа халдлагаас улс, нийгэм, хувь хүний амин чухал ашиг сонирхлыг найдвартай хамгаалах, оршин тогтож хөгжих, цаашид урагшлах чадвартай байх, мөн түүнчлэн дэлхийн хэмжээнд бусад улс орнуудтай амжилттай зохицон, харилцан ашигтай хамтран ажиллах зэргийг баталгаажуулах ийм өөрийн улс, үндэсний байдлыг илэрхийлж байна. Түүнчлэн улс орны нэгдмэл байдал, түүний оршин буй нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хадгалан, бэхжүүлдэг бол хөрш зэргэлдээх улсуудтай хиллэж байгаа улсын хилийн хэсэг бүр өөр өөрийн өвөрмөц онцлогтойгоос үүдэн тухайн чиглэлд тохирсон хилийн аюулгүй байдлыг хангах арга, үйл ажиллагаа нь тухайн нөхцөл байдалд тохирсон онцлогтой байна.

Үндэсний аюулгүй байдал шиг хилийн аюулгүй байдлын төрлүүд нь улсын хилийн хамгаалалтад оролцож байгаа хүч, хэрэгслүүдийн үйл ажиллагааны нутаг дэвсгэр, орон зайн хүчин зүйлээр бус, харин улс оронд учирч байгаа буюу учирч болзошгүй аюул заналын төрлүүдээр тодорхойлогддог. Үүнтэй уялдан улсын хилийн аюулгүй байдлыг бүрэлдүүлж буй чухал төрлүүд нь үндэсний аюулгүй байдлын улс төр, эдийн засаг, цэрэг, экологи, оюун санааны болон бусад төрлүүд болно. Түүнчлэн үндэсний болон хилийн аюулгүй байдлын бүтцийн маргаангүй харьцуулалт нь энэ хоёр аюулгүй байдал адилхан үндэстэйг харуулж байна.

Хилийн тухай хуулийн тавдугаар зүйлд “Монгол Улсын хилийн аюулгүй байдал”-ын талаар доорх байдлаар тусгасан. Үүнд:

Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь (Цаашид “Хилийн аюулгүй байдал” гэх) Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн.

Хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ.

Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого,

харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдана.

Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцна[33] хэмээн "Хилийн аюулгүй байдал" гэх ойлголт, асуудлын үндэс суурийг тавьж тодорхойлсон билээ.

Нөгөө талаар хилийн аюулгүй байдал гэж улсын амин чухал ашиг сонирхлын хамгаалагдсан байдал, бүх нийгмийн болон байгууллага-тусгай бүтцийн итгэл үнэмшилтэй оршин тогтнол, үйл ажиллагаа, мөн түүнчлэн энэ орон зайд хувь хүний хийгээд нийгмийн хамгаалагдсан байдал хангагдсан байх улсын хил дээрх болон хилийн орон зай дахь цэрэг-улс төрийн ба оперативын цагийн байдлын ийм нөхцөлийг хэлж болно.

Монгол Улсад зөвхөн улсын хил дээр үйл ажиллагаа явуулснаар үндэсний ашиг сонирхолын, тэр тусмаа нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, түүний хилийн халдашгүй дархан байдлын хамгаалалтыг хангах боломжгүй. Монгол Улсын хилийн аюулгүй байдлын асуудал нь хилийн хоёр талаар өргөн зурваст, өөрөөр хэлбэл хилийн орон зайд хилийн хамгаалалтын бүх субъектуудын идэвхтэй үйл ажиллагааны нөхцөлд амжилттай шийдвэрлэгдэж чадна.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах явдал нь төрийн үйл ажиллагааны чухал үндсэн чиглэл бөгөөд эцсийн дүндээ, хилийн аюулгүй байдал нь улсын хилийн хамгаалалтад оролцож буй субъектуудын системийн үйл ажиллагаагаар хангагдана. Энэ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх системийн хэсэг болох улсын хилийн хамгаалалт нь улс төр, зохион байгуулалт-эрх зүй, дипломат, эдийн засаг, батлан хамгаалах, тагнуул, оператив-эрэл тагнуул, гааль, байгаль орчин, ариун цэвэр-халдвар судлал, экологийн болон бусад арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх замаар өөрсдийн бүрэн эрхйин хүрээнд Монгол Улсын төрийн эрх мэдлийн байгууллагууд, субъектуудын болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Улсын хилийн хамгаалалт нь хувь хүн, нийгэм, төрийн амин чухал ашиг сонирхлыг хангах бөгөөд түүнийг Монгол Улсын хуулиар тогтоосон бүрэн эрхийнхээ дагуу гүйцэтгэх засаглалын бүх байгууллагууд хэрэгжүүлнэ.

Улсын хил хамгаалах арга хэмжээ нь хилийн арга хэмжээ байна. Хилийн арга хэмжээ нь улс, нийгэм, хувь хүний амин чухал ашиг сонирхолд учирч болзошгүй холбогдох аюул заналын болон хилийн аюулгүй байдлыг хангах нэгдсэн хилийн бодлогын хүрээнд хэрэгжих, аюулгүй байдлын арга хэмжээнүүдийн системд ордог.

Монгол Улсын Засгийн газар үндэсний болон хилийн аюулгүй байдлыг хангах гүйцэтгэх засаглалын эрх мэдлийн байгууллагуудыг удирдана. Хилийн

[33]Монгол Улсын хууль. Хилийн тухай. Уб., 2001. 5 дугаар зүйл.

аюулгүй байдлыг хангах асуудлыг Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газар хариуцна. Энэ утгаараа хил хамгаалах ерөнхий газар нь улсын хил дээр болон хилийн орон зайд улсын хилийн аюулгүй байдлыг хангах, хилийн цэрэг, байгууллагуудын хийгээд өөрөө удирдах ёсны байгууллагуудын системийг тэргүүлдэг. Ерөнхий утгаараа энэ нь доорхи байдлаар илэрхийлэгдсэн. Үүнд:

Монгол Улсын нутаг дэвсгэрийн тусгаар тогтнолын болон улсын хилийн шугамын явалтын хууль бус өөрчлөлтийг гаргуулахгүй байх;

Улсын хилийн дэглэмийг болон хилийн журмын бусад төрлүүдийг сахиулахад;

Улсын хилийн зөрчил гаргуулахгүй, зэвсэг, сум галт хэрэгсэл, тэсрэх дэлбэрэх болон хордуулах бодис, хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх мансууруулах бодисыг улсын хилээр нэвтрүүлэхгүй байх, бусад хууль бус үйл ажиллагааны сувгуудыг илрүүлэх ба хаах;

Улсын хилийн орон зайд төвлөрч буй Монгол Улсын хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй бусад олон тооны аюул заналыг гаргуулахгүй байх ба устгах, ялангуяа улсын үндэсний баялгийг хууль бусаар хил нэвтрүүлэх явдлыг таслан зогсооход;

Хил дээр болон хилийн орон зайд Монгол Улсын үндэсний ашиг сонирхлыг найдвартай хамгаалахад;

Бүх орон зайд Монгол Улсын геополитикийн байр суурийг хадгалах, бэхжүүлэх;

Хилийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд болон сайн хөршийн харилцааг хөгжүүлэхэд нөлөөлөх хилийн дипломат харилцааг хэрэгжүүлэхэд;

Хилийн бүсэд олдвор, хайгуулын үйл ажиллагаанд хяналт тавихад;

Монгол Улсын хилийн орон зайд дотоод улс төрийн тогтвортой байдлыг хангах, гарч болзошгүй зөрчилдөөний намжаах, үндсэн хуулийн журмыг сэргээн сахиулах зайлшгүй шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд;

Улсын хилийн асуудлаар олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд мөн түүнчлэн гадаад улс орны хилийн байгууллагуудтай харилцан ажиллахад;

Монгол Улсын хилийн аюулгүй байдлын зорилгод хүрэхэд чиглэгдсэн бусад арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд тус тус оршиж байна.[34]

[34]В.Пүрэвбаасан. “Хилийн цэргийн албаны аюулгүй байдлыг хангах онол, арга зүй” нэг сэдэвт бүтээл. Уб., 2022. 34 дэх тал.

## Дүгнэлт

Хилийн аюулгүй байдлын тухай ойлголтын талаар шинжлэх ухааны доктор Ш.Арвай, хурандаа Д.Дашдаваа, А.Муратхан, Д.Нямдорж нарын эрдэмтэд судалж олон бүтээлүүд туурвисныг бид бүхэн судалж, ойлгож байгаад 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан хилийн тухай хуулинд тусган, албан ёсны ойлголтыг хуульчлан албажуулжээ.

Хилийн аюулгүй байдлын тухай ойлголтод хилийн хүрээнд явагддаг бүх харилцаа хамардаг учир түүнийг зөв ойлгож, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа, мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд материал дамжуулан худалдаалах, үйлдвэрлэх оролдлого, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг уурын дулаарал хүний амьдрах орчны бохирдол, нэн халдварт өвчний тархалт, олныг хамарсан ядуурал, эмх замбараагүй дүрвэлт, олон улсын терроризмтай тэмцэх, урьдчилан сэргийлэх таслан зогсоох арга хэмжээг бүхэлд нь нь хилийн аюулгүй байдлын тухай ойлголт гэж үзэж болох юм.

Энэхүү үүргийг хэрэгжүүлэхэд хилийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх үндсэн байгууллага болох Хил хамгаалах байгууллагын хэвийн тогтвортой үйл ажиллагаа маш чухал юм. Эндээс Хил хамгаалах байгууллага буюу хилийн цэрэг нь улс орны хэмжээнд улсын хилийг хамгаалах, хязгаар нутагт хилийн аюулгүй байдлыг хангах, байгаль цаг уурын эрс тэс нөхцөлд улсын хил дээр үүсэх аливаа аюул, заналыг эхний ээлжид сөрөн зогсох үндсэн чиг үүрэг бүхий эрсдэлтэй алба бөгөөд тайван цагт цэргийн болон хууль сахиулах чиг үүргийг хамтад нь гүйцэтгэдэг төрийн тусгай албаны онцгой төрөл гэж үзэв.

## Санал

Хил дээр болон хилийн орон зайд үндэсний ашиг сонирхлыг хамгаалах нь олон улсын эрх зүйн, эдийн засгийн, улс төрийн, гаалийн, цагаачлалын, байгалийн, алба-байлдааны болон бусад арга хэмжээ, үйл ажиллагааны нийлмэл цогцолборыг бүрдүүлдгийг тооцон, хилийн орон зайд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын тэр дундаа төрийн захиргааны байгууллагуудын бүрэн эрх, чиг үүргийг тодорхой болгох нь онцгой чухал төдийгүй тэдний үйл ажиллагааг маш тодорхой зохицуулж уялдуулах шаардлагатай байна.

Түүнчлэн хилийн аюулгүй байдлын талаар гаргасан эрдэмтдийн бүтээлийг нийгэм эдийн засгийн өнөөгийн байдалтай уялдуулан салбарын хэмжээнд чиглэл чиглэлээр нь судалж, хэрэгжилтийг хангуулж ажиллах нь зүйтэй юм.

## Эх сурвалжийн жагсаалт


Монгол улсын үндсэн хууль. УБ., 1992.
Үндэсний аюулгүй байдлын тухай хууль.УБ., 2001.
Монгол улсын хилийн тухай хууль. УБ., 2016.
Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ.,2010.
Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. УБ., 2002
Арвай Ш. “Монгол улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог”. УБ., 2015. 9 дах тал.
Арвай Ш. “Улсын хилийн тухай дурсамж, үзэл бодол". УБ. 2005 35 дах тал.

Жекей Х. “Оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд улсын хил хязгаар, нутгийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь”.УБ.,2004. 38. дах тал.
Цэвэл Я. “Монгол хэлний товч тайлбар толь”. УБ., 1966. 60 дах тал
Төртогтох Т. “Улсын хилийн аюулгүй байдал”. УБ., 2004.
Жекей Х. “Оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд улсын хил, хязгаар нутгийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь”. УБ., 2004
Дашдаваа Д. “Улсын хилийн аюулгүй байдлын зарим асуудал”. УБ., 2014.
В.Пүрэвбаасан. “Хилийн цэргийн албаны аюулгүй байдлыг хангах онол, арга зүй” нэг сэдэвт бүтээл. Уб., 2022.